



## ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.mn, http://www.audit.mn

“ШИНГЭН ТУЛШ ШИЛЖУУЛЭН АЧУУЛАХ  
БАЙГУУЛАМЖ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Г.ГАНСҮХ ТАНАА

2017.02.23 № 3/293  
танай -ны № -т

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайландауд аудит хийв.

### Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ЫН удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ЫН 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бodoх бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ЫН 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТИН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.20\Bichig\_Kherereg\Yawsan\_Bichig\2017\0222SA\G12.docx



## “ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ” ТӨҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах  
хаягаар харилцана уу:

Санхүүгийн Аудитын Газрын дарга  
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: 261885  
Цахим хаяг: [sambuunyamya@audit.gov.mn](mailto:sambuunyamya@audit.gov.mn)

Ахлах аудитор: Н.Батсайхан  
Утас: 260512  
Цахим хаяг: [batsaikhann@audit.gov.mn](mailto:batsaikhann@audit.gov.mn)

Хавсралт 1:

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үндэсний аудитын газар  
Байршил: Чингэлтэй дүүрэг  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2017 оны 2 дугаар сар

## **АГУУЛГА**

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохиорох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дугаар заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Гүйцэтгэх захирал санхүүгийн тайлангаа СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 01-наас 2017 оны 03 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн Энур Аудит ХХК-ийн аудиторууд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь 2016 оны санхүүгийн тайлангаа 2017 оны 2 дүгээр сарын 02-нд 23 тоот албан бичгээр Энур Аудит ХХК-т ирүүлсэн байна.

Энур Аудит ХХК аудитыг 2016 оны 10 дугаар сарын 01-нээс 2017 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын захирал нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон

орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”, “Компанийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь төмөр замаар тээвэрлэн нийлүүлэгдэж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын вагонцестерн болон автоцистернд шилжүүлэн ачих, хадгалах үндсэн чиг үүрэг бүхий аж ахуйн тооцоотой Төрийн өмчит үйлдвэрийн газар мөн. Үйл ажиллагааны үндсэн зорилт нь Монгол улсаас газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цашид тус байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн чиг удирдлагаар хангахад оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг Төрийн өмчийн хороо, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасан байна.

ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд компанийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 131 дугаар тогтоолоор “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын дүрэм, албан тушаалын жагсаалт, орон тооны хягаарыг шинэчлэн баталсан байна.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур узуулэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 19-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгээ "Аж ахуйн нэгжийн нягтлан бodoх бүртгэлийн заавар, нягтлан бodoх бүртгэлийн дансны жишиг жагсаалт" болон "Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах норм тогтоох" зэрэг заавар журмын өөрчлөлтийг тусган шинэчлэн боловсруулж 2017 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөх ажиллахаар болсон байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан заавар, журам, аргачлалтай нийцсэн байна.

"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Ординат ХХК-ийн Винница санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### Материаллаг байдал:

Гүйцэтгэлийн үе шатанд ТАБ-СТА-В-1 маягтыг ашиглан материаллаг байдлын түвшинг тогтооходоо нийт хөрөнгийг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурийг 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт орлого, нийт зардлаас тооцоход хэтэрхий бага байгаа тул нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс шинэчлэн тооцлоо. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 1 хувиар буюу 148.4 сая төгрөгөөр тооцоов.

Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

#### Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. "Шингэн түлш

шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

**Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-н 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн хорооны 2015 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 812 дугаар тогтоолоор нийт 1,752.0 сая төгрөгийн орлого олж, 1,247.8 сая төгрөгийн зардал гаргаж, 50.4 сая төгрөгийн орлогын албан татвар төлж, 453.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь тайлант онд нийт 736.3 сая төгрөгийн орлого олж, 675.5 сая төгрөгийн зардал гаргаж, 8.7 сая төгрөгийн орлогын татвар төлж, 52.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих үйлчилгээнээс 398.8 сая төгрөг, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах үйлчилгээнээс 319.6 сая төгрөг нийт 718.5 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, үндсэн бус үйл ажиллагааны 17.8 сая төгрөгийн орлого олсон байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 41.3 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 148.9 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тасарсан гол шалтгаан нь

1. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах үйлчилгээний орлогын үнэ тарифыг бууруулнаас газрын тосны бүтээгдэхүүн хадгалах орлогын төлөвлөгөө биет хэмжээгээр биелсэн боловч нийт үнийн дунгээр орлогын төлөвлөгөө 76.4 сая төгрөгөөр тасарсан байна.
2. ОХУ манай улсад нийлүүлэх шатахууны үнээ удаа дараа бууруулсантай холбоотойгоор импортлогч компаниуд ОХУ-аас бүтээгдэхүүн ихээр авах болсон нь БНХАУ-аас импортлох шатахууны хэмжээ багасахад нөлөөлсөн байна.

**Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар судлаж үзэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад хуульд заасан мэдээллийг байршуулсан ба 5.0 саяас дээш үнийн дүнтэй 781.3 сая төгрөгийн 30 орлогын гүйлгээ, 450.9 сая төгрөгийн 40 зарлагын гүйлгээ болон зорилтот түвшиний төлөвлөгөө гүйцэтгэлийг байршуулсан байна.

**Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

**Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланда нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, авлага өглөг, үйл ажиллагааны орлого, зардлын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 64.5 хувь, мөнгөн хөрөнгийн 75.3 хувь, урьдчилж төлсөн тооцооны 48.4 хувь, нийт зардлын 52.7 хувь, нийт бараа материалын 72.0 хувь, үндсэн хөрөнгийн 31.5 хувийг тус тус эзэлж байна.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь Уул уурхайн яамны 2016 оны 12-р сарын 20-ны өдрийн 3/1135 тоот албан бичгийн дагуу тус яамны дуусаагүй үйлдвэрлэл данснаас хассан 3,593.0 сая төгрөгийн шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн өргөтгөлийн автоматжуулалтын тоног төхөөрөмж, программ хангамжийг балансад шилжүүлэн авч үндсэн хөрөнгөөр бүртгэсэн ба ТӨХ-ны БЗГазрын шийдвэр байхгүй байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг  
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 2016 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,021.5 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн. 2016 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 14 нэр төрлийн 13.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1. 2-д “Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, 20.1.3-д “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Менежментийн захидалаар батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлж ажиллах, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар батлагдсан төлөвлөгөөнд тодотгол хийж байх талаар аудитын зөвлөмж хүргүүлэв.

2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дууссан 42 нэр төрлийн 178.2 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах хугацааг дахин тогтоож, үнэлж бүртгээгүй байгаа нь НББОУС 16 хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай

хуулийн 31 дугээр зүйлийн 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагатай зөвшилцэн тогтоох" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидааар үлдэгдэл өртөггүй үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацааг дахин тогтоож, үнэлж бүртгэх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

**Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:**

1. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 34 нэр төрлийн 28.0 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалыаар бүртгэсэн ба хөрөнгийн ангилал буруу хийгдсэнээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа эдгээр хөрөнгөд элэгдэл тооцоогүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидааар хөрөнгө ба бараа материалыг НББОУС болон Сангийн сайдын батлан гаргасан нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх заавар журмын дагуу зөв ангилж тайлagnаж байх, бараа материалыаар бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг эрх бүхий байгууллагаар шийвэр гаргуулж, үндсэн хөрөнгөөр залруулж бүртгэх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

"Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

1. Уул уурхайн яамнаас балансад шилжүүлэн авч бүртгэсэн 3,593.0 сая төгрөгийн шингэн тулш шилжүүлэн ачих байгууламжийн өргөтгөлийн автоматжуулалтын тоног төхөөрөмж, программ хангамжийн эх үүсвэрийг ТӨХ-ны БЗГазраар шийдвэрлүүлж бүртгэх.

2. Засгийн газрын 2016 оны 192 дугаар тогтоолоор "Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын эзэмшлийн 12 айлын орон сууцыг хувьчлахаар шийдвэр гарсан ба орон сууцны хувьчлалтай холбоотой материалыг Сангийн яамнаас хянан үзэх хувьчлахыг зөвшөөрсэн байна. Дээрх хувьчлалтай холбоотой ТӨХ-ны шийдвэр гараагүй байгаа.

**Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 222.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс аудитын явцад 2.6 сая төгрөгийн алдааг запруулан бүртгэж, 219.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар менежментийн захидаар 4 зөвлөмж хүргүүлсэнээс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- ТӨХорооны шийдвэр гараагүй шалтгаанаар бараа материалаар бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд запруулга хийгээгүй.
- Зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайллагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, хавсралтууд тус тус хавсаргав.

**2017 оны 3 дугаар сар**

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР

Т.БАТЧИМЭГ

Шингэн Түлш Шилжүүлэн Ачих Байгууламж ТӨҮГ

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2016 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

Балансын зүйл	Аудит хийхийн өмнөх үлдэгдэл		Аудитлагдсан үлдэгдэл
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>ХӨРӨНГӨ</b>	-	-	-
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	312,139,279,05	142 999 069,33	142 999 069,33
Дансны авлага	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага	-	311 029,53	311 029,53
Бараа материал	137,658,975,08	135 658 756,38	135 658 756,38
Урьдчилж төлсөн төлбөр тооцоо	16 108 808,74	5 400 000,00	5 400 000,00
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>465 907 062,87</b>	<b>284 368 855,24</b>	<b>284 368 855,24</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	-	-	-
Үндсэн хөрөнгө	10 701 649 649,43	13 585 162 681,99	13 585 162 681,99
Биет бус хөрөнгө		973 647 528,95	973 647 528,95
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10 701 649 649,43</b>	<b>14 558 810 210,94</b>	<b>14 558 810 210,94</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11 167 556 712,30</b>	<b>14 843 179 066,18</b>	<b>14 843 179 066,18</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-	-
<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-	-
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Урьдчилж орсон орлого	-	-	3 593 000 000,00
Урт хугацаат өр төлбөр	-	-	-
<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3 593 000 000,00</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-	-
Өмч: - төрийн	11 242 009 716,00	14 869 843 049,32	11 276 843 049,32
Хуримтлагдсан ашиг	(74,453,003,70)	(26 663 983,14)	(26 663 983,14)
Тайлант үеийн ашиг	21,852,443,86	52 159 540,56	52 159 540,56
Өмнөх үеийн ашиг	(96,305,447,57)	(78 823 523,70)	(78 823 523,70)
<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11 167 556 712,30</b>	<b>14 843 179 066,18</b>	<b>11 250 179 066,18</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11 167 556 712,30</b>	<b>14 843 179 066,18</b>	<b>14 843 179 066,18</b>

TU2016.05.05.05

Шингэн Түлш Шилжүүлэн Ачих Байгууламж ТӨҮГ

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН  
2016 оны 12-р сарын 31

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого /Цэвэр/	491 349 622,55	718 472 672,75
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	491 349 622,55	718 472 672,75
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	545 309 634,53	655 286 628,27
Бусад ашиг (алдагдал)	83 311 797,85	(2 340 365,92)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	29 351 785,87	60 845 678,56
Орлогын татварын зардал	7 499 342,00	8 686 138,00
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>21 852 443,87</b>	<b>52 159 540,56</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>21 852 443,87</b>	<b>52 159 540,56</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
<b>Орлогын нийт дүн</b>	<b>21 852 443,87</b>	<b>52 159 540,56</b>



Шингэн Түлш Шилжүүлэн Ачих Байгууламж ТӨҮГ

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
2016 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2014 оны 12-р сарын 31-нээрх улдэгдэл	4 992 085 716,00	-	241 234 552,43	5 233 320 268,43
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	21 852 443,87	21 852 443,87
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	6 249 924 000,00	-	-	6 249 924 000,00
Зарласан ногдол ашиг	-	-	(337 540 000,00)	(337 540 000,00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2015 оны 12-р сарын 31-нээрх улдэгдэл	11 242 009 716,00	-	(74 453 003,70)	11 167 556 712,30
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	52 159 540,56	52 159 540,56
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	34 833 333,32	-	-	34 833 333,32
Зарласан ногдол ашиг	-	-	(4 370 520,00)	(4 370 520,00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2016 оны 12-р сарын 31-нээрх улдэгдэл	11 276 843 049,32	-	(26 663 983,14)	11 250 179 066,18



TTG2016 № 5215545

Шингэн Түлш Шилжүүлэн Ачих Байгууламж ТӨҮГ

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2016 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	630 331 450,33	815 861 978,54
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	540 619 584,80	790 319 940,00
Бусад мөнгөн орлого	89 711 865,53	25 542 038,54
Мөнгөн зарлагын дүн (-)	646 343 755,19	709 078 803,26
Ажиллагчдад төлсөн	297 893 162,00	315 206 225,00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	71 863 049,57	85 566 260,11
Бараа материал худалдан авахад төлсөн	8 044 500,00	-
Ашиглалтын зардалд төлсөн	52 446 711,00	64 228 300,00
Түлш шатахуун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	65 303 562,01	20 634 080,00
Татварын байгууллагад төлсөн	60 188 213,61	97 486 717,75
Даатгалын төлбөрт төлсөн	1 900 190,00	1 573 850,00
Бусад мөнгөн зарлага	88 704 367,00	124 383 370,40
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(16 012 304,86)</b>	<b>106 783 175,28</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	(358 960 183,00)	(271 552 865,00)
Үндсэн хөрөнгө олих эзэмшихэд төлсөн	(358 960 183,00)	(271 552 865,00)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(358 960 183,00)</b>	<b>(271 552 865,00)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	(37 540 000,00)	(4 370 520,00)
Төлсөн ногдол ашиг	(37 540 000,00)	(4 370 520,00)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(37 540 000,00)</b>	<b>(4 370 520,00)</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(412 512 487,86)	(169 140 209,72)
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>724 651 766,91</b>	<b>312 139 279,05</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>312 139 279,05</b>	<b>142 999 069,33</b>



Шингэн Түлш Шилжүүлэн Ачих Байгууламж ТӨҮГ

ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН  
2016 оны 12-р сарын 31

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<i>I. Орлого</i>				
Газрын тосны бутээгдэхүүн шилжүүлэн ачих	1 344 000 000,00	398 825 901,80	(945 174 098,20)	29,7
Газрын тосны бутээгдэхүүн хадгалах	396 000 000,00	319 646 771,00	(76 353 229,00)	80,7
12 айлын орон сууц, гараж түрээслэж олох орлого	12 000 000,00	17 873 852,10	5 873 852,10	148,9
<b>Орлогын дүн</b>	<b>1 752 000 000,00</b>	<b>736 346 524,90</b>	<b>(1 015 653 475,10)</b>	<b>42,0</b>
<i>II. Үйл ажиллагааны зардал</i>				
Цалин: Цалин хэлс	385 135 000,00	381 365 320,30	(3 769 679,70)	99,0
Шагнал урамшуулал	3 000 000,00	5 296 380,00	2 296 380,00	176,5
НДШ	46 217 000,00	46 178 271,10	(38 728,90)	99,9
Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ	40 000 000,00	13 544 200,00	(26 455 800,00)	33,9
Цахилгааны зардал	72 936 600,00	88 287 649,50	15 351 049,50	121,0
Албан томилолт, баярын арга хэмжээний зардал	12 477 200,00	3 909 550,00	(8 567 650,00)	31,3
Бичиг хэргийн зардал	1 500 000,00	1 157 154,60	(342 845,40)	77,1
Элэгдлийн зардал	480 418 300,00	29 229 876,40	(451 188 423,60)	6,1
Шуудан холбооны зардал	4 056 000,00	1 686 149,50	(2 369 850,50)	41,6
Шатахууны зардал	27 424 320,00	25 798 075,80	(1 626 244,20)	94,1
Аж ахуйн хэрэгцээнд	2 118 000,00		(2 118 000,00)	-
Авто сэлбэгийн зардал масло тосол	7 000 000,00	7 547 652,10	547 652,10	107,8
ТХ-ийн татвар, замын хураамж, даатгал, тэмдэгтийн хураамж	2 500 000,00	1 707 050,00	(792 950,00)	68,3
Зам арчлалтын төлбөр	45 000 000,00		(45 000 000,00)	-
12 айлын орон сууцны цэвэр, бохир ус	23 000 000,00	11 438 067,00	(11 561 933,00)	49,7
Банкны үйлчилгээний хэлс	18 000,00	18 000,00	-	100,0
Банк хоорондын бэлэн бус гүйлгээний шимтгэл	60 000,00	78 600,00	18 600,00	131,0
Газрын төлбөр	422 600,00	422 600,00	-	100,0
Усны төлбөр	64 800,00	64 800,00	-	100,0
Гал хөдөлмер хамгааллын зардал	11 334 850,00	2 854 082,70	(8 480 767,30)	25,2
Хэмжүүр хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын зардал	3 500 000,00	43 200,00	(3 456 800,00)	1,2
Үл хөдлөх хөрөнгийн татвар	9 035 400,00	5 616 000,00	(3 419 400,00)	62,2
Аудитын зардал	12 000 000,00	5 454 545,50	(6 545 454,50)	45,5
Сургалтын зардал	8 000 000,00	2 410 000,00	(5 590 000,00)	30,1

Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал	6 000 000,00		(6 000 000,00)	-
Лабораторын итгэмгэмжлэл авахад шаардагдах зардал	1 250 000,00		(1 250 000,00)	-
Хөдөлмөрийн чадвар түр алдсан болон дотоод журмын дагуу олгогдох бусад тэтгэмжүүд	2 000 000,00	2 069 906,50	69 906,50	103,5
Бусад зардал /Үйл ажиллагаа явуулах явцад гарч ирэх зардал/	20 000 000,00	19 109 497,40	(890 502,60)	95,5
Магадлашгүй зардал 1 %	21 354 680,70	20 214 218,00	(1 140 462,70)	94,7
<b>Зардлын нийт дүн</b>	<b>1 247 822 750,70</b>	<b>675 500 846,40</b>	<b>(572 321 904,30)</b>	<b>54,1</b>



**“ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН  
АЧИХ БАЙГУУЛАМЖ” ТӨҮГ-ЫН  
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Менежментийн захидал**

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

Асуудал 1  
Зорилтот түвшний төлөвлөгөөний талаар

Асуудал 2  
Үндсэн хөрөнгийн талаар

**Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:**

Асуудал 1  
Бараа материалын талаар

**2017 оны 2 дугаар сар**

## **Менежментийн захидал**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг Шингэн Түлш Шилжүүлэн Ачих Байгууламж ТӨҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидалын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Төрийн Аудитын Байгууллагын аудитын горимд үндэслэсэн болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Зорилтот түвшний  
төлөвлөгөөний талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

1. 2016 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,021.5 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн. 2016 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 19 нэр төрлийн 13.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан нь “ТБОНӨТХ-ийн “Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг гэсэн 20 зүйлийн 20.1.2 “Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, 20.1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар баттуулан биелэлтийг хангах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Батлагдсан зорилтот түвшингийн орлого, зардлын төлөвлөгөөг биелүүлж ажиллах, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар батлагдсан төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулах.

**Эрсдэлүүд**

Зорилтот түвшний төлөвлөгөө тасрах, батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах

Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх,

Хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгө бэлтгэсэн, бүртгэж тайлагнасан байх,

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

<b>Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
---	----------------------------------

**ҮАГ-ЫН АЖИГЛАЛТ**

2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дууссан 42 нэр төрлийн 178.2 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах хугацааг дахин тогтоож, үнэлж бүртгээгүй байгаа нь НББОУС 16 хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хороодлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” заалттай нийцэхгүй байна.

**ҮАГ-ЫН ЗӨВЛӨМЖ**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн, шийдвэр гаргуулж үлдэгдэл өртөгтгүй үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацааг дахин тогтоож, үнэлж бүртгэх.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлан  
илэрхийлэгдэх,  
Удирдлагад буруу мэдээлэл хүрэх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 1: Бараа материал****Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт**

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 34 нэр төрлийн 28.0 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалыаар бүртгэсэн ба хөрөнгийн ангилал буруу хийгдсэнээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа эдгээр хөрөнгөд элэгдэл тооцоогүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Бараа материалыаар бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж үндсэн хөрөнгөөр бүртгэх, хөрөнгө бараа материалыг НББОУС-16 болон Сангийн яамнаас батлан гаргасан нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх заавар журмын дагуу зөв ангилж тайлagnаж байх.

**Эрсдэлүүд**

Бараа материал, хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдэх

Санхүүгийн тайлан болон тайлант хугацааны ашиг алдагдал буруу илэрхийлэгдэх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.